Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн
байнгын хорооны 2026 оны 04 дүгээр
сарын 29-ны өдрийн 04 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ШҮҮГЧ БУС
ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ТУХАЙ

НЭГ: ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:

| | |
|---|---|
| 1.1 | **Эцэг/эхийн нэр**: Далантай<br>**Ургийн овог**: Цорос-Анар<br>**Нэр**: Өнөржаргал<br>**Хүйс**: Эмэгтэй<br>**Төрсөн он**: [redacted]<br>**Төрсөн газар**: Дархан-Уул аймаг<br>**Одоо оршин суугаа аймаг/ нийслэл, сум/ дүүрэг**: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, |
| 1.2 | **Иргэний харьяалал:**<br>Монгол Улсын иргэн мөн үү /тийм, эсхүл үгүй гэж бичих/ |
| | Тийм |
| 1.3 | **Насны дээд хязгаар:**<br>Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн үү /тийм, эсхүл үгүй гэж бичих/ |
| | Үгүй |
| 1.4 | **Шүүгчийн албан тушаал**<br>Шүүгчээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих/ |
| | Үгүй |
| 1.5 | **Улс төрийн болон намын удирдах албан тушаал**<br>Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаа юу, эсхүл эрхэлж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих/ |
| | Үгүй |
| 1.6 | **Эрүүгийн хариуцлага**<br>Эрүүгийн хариуцлага хүлээж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих/ |
| | Үгүй |
| 1.7 | **Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн**<br>Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаж байгаа юу, эсхүл ажиллаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих/ |
| | Үгүй |
| 1.8 | **Монгол Улсын Их Хурлаас Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнээр томилохоос татгалзаж байсан**<br>Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшсэн боловч Монгол Улсын Их Хурлаас томилохоос татгалзаж байсан уу /тийм, эсхүл үгүй гэж бичих/ |
| | Үгүй |

## ХОЁР: ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

| | |
|---|---|
| 2.1 | Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний хувьд хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ. |
| | **1. Сонгон шалгаруулалтын ил тод байдал, залгамж чанар**<br>Миний бие Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд сонгогдсоноор шүүхийн шинэтгэлийн үйл явц, бодлогын залгамж чанар, өмнөх бүрэлдэхүүний ололт, амжилтыг үргэлжлүүлж, амжаагүй ажлуудыг хэрэгжүүлэхэд анхаарлаа хандуулна. Шүүхийн ил тод байдал шүүхүүдээс гадна шүүхийн захиргааны байгууллага, тэр дундаа Шүүхийн ерөнхий зөвлөлийн үйл ажиллагаанд хамаарна. Ил тод байдлын манлайллыг шүүхийн захиргааны төв байгууллагаас эхлэх ёстой.<br>Нэн түрүүнд, сор болсон шилдэг хуульчдаас шүүгчийг шилж олох, сонгон шалгаруулах үйл явцыг нээлттэй явуулах шаардлагатай. Ялангуяа шүүгчид тавих ёс зүйн шалгалтыг зөвхөн өнөөдрийн практик үйлдэл дээр биш, тухайн хүний бага насны хүмүүжил, арван жилийн сургуулиас төлөвшсөн суурь ёс суртахуун, хүмүүжлийн түүхийг нь нарийвчлан үнэлдэг хэлбэрт шилжүүлэх хэрэгтэй. Ингэж байж бид жинхэнэ ёс зүйтэй, төлөвшсөн шүүгчийг шилж сонгох боломж бүрдэнэ. Үүний тулд шүүгчийн сонгон шалгаруулалтад бүртгүүлсэн нэр дэвшигчдийг бэлтгэх, өмнөх шалгалтын материалыг нийтэд нээлттэй байршуулах ажлаас эхлэх нь зүйтэй.<br>Мөн шүүхийн захиргааны төв байгууллагын хувьд Төрийн албаны зөвлөлийн тусгай шалгалтыг зохион байгуулж буй Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Салбар зөвлөлийн үйл ажиллагааг ил тод болгож, иргэд, олон нийтийн хөндлөнгийн хяналт хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна.<br>**2. Шүүхийн үйлчилгээг нээлттэй, ил тод байлгахад цахим шилжилтийг хиймэл оюун ухаанд суурилсан дараа үеийн технологид тулгуурлан хөгжүүлэх**<br>Өнөөгийн байдлаар шүүхийн захиргааны ажилтнууд хоорондоо уялдаагүй хорь гаруй тусдаа программ дээр нэг ажлыг дахин давтан хийж, мэдээлэл хайж цаг алдах явдал түгээмэл байна. Захиргааны хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн систем л гэхэд ердөө 27 хувиас бусад нь гар ажиллагаагаар хийгдэж нь шүүхийн ажлын ачааллыг зохиомлоор нэмэгдүүлэх нэг шалтгаан болж байна. Үүний зэрэгцээ программ хангамжаас илүүтэй технологийн суурь бааз, цахилгааны найдвартай эх үүсвэр дутагдалтайгаас үйл ажиллагаа тасалдах эрсдэл үүсдэг. Мөн иргэдийн хувьд цахим үйлчилгээ авахын тулд заавал тоон гарын үсэгтэй байх, системийг ашиглах өндөр ур чадвар, эзэмшсэн байхыг шаардаж байгаа нь дижитал хуваагдлыг үүсгэж, хүртээмжийг хязгаарлаж байна.<br>Иймд шүүхийн үйлчилгээнд хүний эрхийн зөрчилгүй, нээлттэй, ил тод, хараат бус бие даасан, шударга, хариуцлагатай шүүх засаглалыг бэхжүүлэх, шүүхийн захиргааг чадавхжуулахын тулд цахим шилжилтийг шинэ түвшинд гаргах шаардлагатай байна. Үүний тулд шүүхийн цахим системд хүний оролцоог багасгаж, төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцоог шууд интеграцид оруулан уялдаа холбоог хангахад онцгой анхаарна. Мөн шүүхийн нээлттэй өгөгдлийг (open data) зөвхөн хэрэглэгч харахад зориулагдсан идэвхгүй хэлбэрээс гаргаж, иргэд ашиг шимийг нь бодитоор хүртэх, хөндлөнгийн хяналт тавих боломжтой формат руу шилжүүлнэ.<br>Энэхүү шинэчлэлийн хүрээнд хэрэглэгчдийн цахим хэрэглээний ур чадварыг суулгах замаар олон нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлж, олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн шүүхийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. |

| | |
|---|---|
| | Түүнчлэн хиймэл оюун ухаанд суурилсан цахим туслахыг нэвтрүүлнэ. Үүний үр дүнд шүүхийн захиргааны ажилтнуудын ажлын ачааллыг эрс бууруулж, орон тоо нэмэгдүүлэх шаардлагагүйгээр, төсөвт хэмнэлттэй, үр ашигтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, хиймэл оюун ухаан болон үүлэн технологид суурилсан шүүхийн цахим шилжилтийн ажлыг тууштай үргэлжлүүлэхэд анхаарлаа хандуулна.<br>**3.Шүүхийн хараат бус байдал, хөндлөнгийн хяналт ба иргэдийн мэдэх эрхийг хангах механизм**<br>Ардчилсан нийгэмд иргэдийн шүүхэд хандах эрх, шүүхийн үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналт нь харилцан хамааралтай үнэт зүйлс бөгөөд шүүхийн шийдвэр олон нийтийн эрүүл шүүмжлэлээс ангид байх учиргүй. Энэ нь шүүхийн ил тод, хариуцлагатай байдлыг хангах үндсэн зарчим юм. Гэвч энэхүү нээлттэй байдлыг ашиглан тодорхой бүлгүүд зориудаар худал мэдээлэл (misinformation) түгээж, шүүгчдийн нэр хүнд, шийдвэрийн үнэн зөв байдалд эргэлзээ төрүүлэх замаар шүүхийн хараат бус байдалд сөргөөр нөлөөлөх, улмаар иргэдийн шүүх засаглалд итгэх итгэлийг сулруулах эрсдэлийг үүсгэдэг.<br>Тиймээс иргэдийн бодит мэдээлэл авах, мэдэх эрхийг баталгаажуулахын зэрэгцээ худал таамаг, мушгин гуйвуулалтаас урьдчилан сэргийлэх бодит механизмыг бий болгох шаардлагатай. Үүний тулд хэвлэл мэдээллийн болон иргэний нийгмийн байгууллагуудтай ажиллах уялдааг эрс сайжруулснаар, шүүхийн үйл ажиллагааг хөндлөнгийн хяналттай, нээлттэй байлгахын зэрэгцээ албаны мэдээллийг иргэдэд богино хугацаанд шуурхай хүргэдэг тогтолцоо руу шилжинэ. Ялангуяа олны анхаарал татсан хэргүүд дээр урьдчилсан бэлтгэл хангах хамтарсан баг ажиллуулж, шүүх хурлын процесс болон шийдвэрийн хураангуйг иргэдэд хамгийн хүртээмжтэй, ойлгомжтой эх сурвалжаар дамжуулан цаг алдалгүй хүргэхэд онцгойлон анхаарна. Ингэснээр хүний хувийн халдашгүй байх эрхийг хангах, нөлөөллийн мэдүүлгийг ил тод болгох, худал мэдээллийг цаг тухайд нь засах боломж бүрдэх юм. Мөн шүүх, шүүгчдийн үйл ажиллагаанд ирж буй аливаа шүүмжлэлийг хүлээж авдаг эрүүл механизмыг бүрдүүлж, шүүгч нар өөрсдөө дотоод үйл ажиллагаагаа илүү нээлттэй, ил тод болгох замаар олон нийтийн зүгээс үүсэх эрсдэл, сорилтуудыг даван туулна.<br>Энэхүү худал мэдээллээс хамгаалах, иргэдийн мэдэх эрхийг хангах шуурхай тогтолцоог практикт үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим мэдээллийн урсгалын хурдыг харгалзан, мэдээллийн шинж чанарыг:<br>а) тогтмол өгч байх ёстой мэдээлэл, б) цаг үеийн буюу тухайлсан мэдээлэл гэж зааглан бэлтгэх, түгээх арга замыг ялгамжтай байдлаар зохицуулах хэрэгтэй.<br>Ялангуяа цаг үеийн буюу олны анхаарал татсан тодорхой хэрэг маргаан, шийдвэрийн талаарх мэдээллийг цаг тухайд нь, албаны бөгөөд бодитой мэдээллээр шуурхай хангах тухайлсан “арга зүй” боловсруулах шаардлагатай бөгөөд энэ чиглэлд шүүхийн салбарт хэрэгжиж буй төслүүдийн “media-judge” зэрэг арга туршлагыг нэвтрүүлэхэд хамтран ажиллах ёстой. Мөн “Шүүхийн суваг”-тай хамтран иргэдэд шүүхийн үйл ажиллагааг сурталчлан таниулах, иргэдэд эрх зүйн мэдлэг олгох замаар тэдний шүүхэд хандах эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах боломжийг эрчимжүүлнэ. Үүний зэрэгцээ шат шатны шүүхийн олон нийттэй харилцах ажилтны арга зүй, ажлын зохицуулалтад мониторинг хийж, тэднийг дээрх зорилгод нийцсэн шинэлэг, бүтээлч арга замаар ажиллуулахад онцгойлон анхаарч ажиллана.<br>**4. Шүүхийн хүний нөөцийн чадавх, тасралтгүй хөгжил ба шүүхэд хандах эрхийн баталгаа** |

| | |
|---|---|
| | Шүүхийн захиргааны ажилтны хүний нөөцийг бэлтгэх, бүрдүүлэх үйл ажиллагааг хууль зүйн их, дээд сургуулиудтай стратегийн түншлэлийн хүрээнд хамтран хэрэгжүүлэх нь төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, урсгал зардлыг хэмнэх практик ач холбогдолтой төдийгүй иргэдийн шүүхэд хандах эрх (шүүхийн хүртээмж)-ийг бодитой хангахад институцийн суурь дэмжлэг болно. Шинээр томилогдсон албан хаагчдыг системтэй сургаж, мэргэшүүлдэг болсноор практик үйл ажиллагаанд хууль хэрэглээний болон процедурын алдаа зөрчил гаргахаас урьдчилан сэргийлж, иргэдийн шударгаар шүүлгэх эрх зөрчигдөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.<br>Шүүхийн захиргааны ажилтныг мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулахдаа шүүгчийн хууль хэрэглээний төрөлжсөн хөтөлбөрийг шүүхийн захиргааны ажилтны сургалттай нягт уялдуулах нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэгдмэл байдлыг хангаж, шүүх, шүүхийн захиргааны үйл ажиллагааны чанар, хүртээмжийг сайжруулах хамтын ажиллагааг чанаржуулна. Түүнчлэн сургалтын нэгдсэн төлөвлөгөө, хугацааг оны эхнээс нарийвчлан гаргаж тогтмолжуулснаар шүүхийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр ажилтнуудыг сургалтад иж бүрэн хамруулах, сурч хөгжих нөхцөл бололцоо бүрдэх юм.<br>Энэхүү хүний нөөцийн тасралтгүй хөгжлийг хангах, ажлын бүтээмжийг бодитоор үнэлэхдээ хөндлөнгийн хяналт-ын механизмыг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай. Үүний тулд шүүхийн захиргааны ажилтнуудын ажлын ачаалал, чиг үүргийн давхардал, хийдлийг илрүүлэх, ажлын үр бүтээмжийг бодитой тогтоох зорилгоор хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар ажлын байрны зураг авалт (job shadowing / work sampling) хийлгэх нь нэн чухал ач холбогдолтой. Ийнхүү хөндлөнгийн хараат бус үнэлгээгээр шүүхийн хүний нөөцийн бодит нөхцөл байдал, ачааллыг тодорхойлсноор процессын гацааг арилгах, чиг үүргийг оновчтой хуваарилах шинжлэх ухааны үндэслэлтэй менежментийг нэвтрүүлэх боломж бүрдэнэ. |

## ГУРАВ.МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА

| Д/д | Шалгуур үзүүлэлт |
|---|---|
| 3.1 | **Эрх зүйч мэргэжлээр ажилласан байдал**<br>Хүсэлт гаргагч нь эрх зүйч мэргэжлээр ажилласан ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалаар тодорхойлон бичих бөгөөд ажил тус бүрийг эрхэлж байсныг нотлох баримтыг хавсаргана. Ажил тус бүрийг тодорхойлохдоо дараах мэдээллийг заавал бичнэ:<br>-албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа;<br>-ажлын байрны тодорхойлолтын гол агуулга;<br>-удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/;<br>-тухайн албан тушаал эрхэлж байхдаа хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан таваас доошгүй хүний нэр /нэрс аль болох давхцахгүй байх/, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/. |

**Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Тамгын газрын даргын албан тушаалд одоогоор 3 жил 7 сар. 2022.03.17-ны өдрөөс одоог хүртэл.**

-Шүүхийн тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.1 дэх хэсэгт заасан шүүхийн Тамгын газрын захиргааны удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлнэ. /Уг хуулийн 71-75 дугаар зүйлд заасан чиг үүрэг, шүүхийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах , хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэд хяналт тавих, шүүхэд ирүүлсэн хэрэг, нэхэмжлэл, гомдол хүсэлтийг хүлээн авч бүртгэх, шүүхийн бичиг хэрэг, захидал харилцаа, шуудан, архивын үйл ажиллагааг зохион байгуулах, шүүхийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, эзэмшил, ашиглалт, хамгаалалтыг зохион байгуулах, хэргийн эд мөрийн баримтыг хадгалах, зөөвөрлөх, холбогдох шийдвэрийг хэрэгжүүлэх, шүүн таслах ажиллагааны болон бусад ажиллагааны тоон мэдээллийг гаргах, иргэн хуулийн этгээдээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахгүй асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуульд заасны дагуу шийдвэрлэж, хариу өгөх болон хуульд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, хуулиар хүлээлгэсэн чиг үүрэг, "Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого", "Шүүхэд мэдээллийн технологи, шүүхийн үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх нэгдсэн бодлого"-ыг тухайн шүүхэд хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг Ерөнхий зөвлөл болон Төсвийн ерөнхийлөн захирагчийн өмнө хариуцна.

1. Удирдах албан тушаалтны нэр: Удирдах албан тушаалтны нэр: Д. Зүмбэрэллхам, /2021.12-2022.12 он/

-Холбоо барих мэдээлэл: Монгол Улсын гавьяат хуульч, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, гишүүн асан, Дотоод хэргийн их сургуулийн "Хүндэт профессор", Хууль зүйн шинжлэн ухааны доктор (Sc.D) Д.Зүмбэрэллхам zumberellham@judcouncil.mn, [redacted] Монгол Улсын гавьяат хуульч, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, гишүүн асан, Дотоод хэргийн их сургуулийн "Хүндэт профессор", хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D),

2. Ажил хэргийн харилцаатай : О.Сэлэнгэ

-Холбоо барих мэдээлэл: Сурагчдын холбооны ерөнхийлөгч асан, сургагч багш, selenge137@gmail.com , [redacted] [redacted],

3. Ажил хэргийн харилцаатай: М.Жамъянчойжил

-Холбоо барих мэдээлэл: jamiyanchoijil@iaac.mn, Авилгатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, коммиссар (Боловсролын салбар хариуцсан), [redacted], Авилгатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар, Боловсролын салбар хариуцсан. [redacted]

4.Өөрийн удирдлагад ажилладаг: С.Тэмүүлэн

Холбоо барих мэдээлэл: Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Тамгын газар шүүгчийн туслах асан, өмгөөлөгч, temuulentemuulen38@yahoo.com, [redacted], Улаанбаатар хот, [redacted]

4.Өөрийн удирдлагад ажилладаг: Г.Рэвгээсүрэн

Холбоо барих мэдээлэл: Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Тамгын газар нягтлан, Revgeesuren.2017@gmail.com , [redacted]

| | |
|---|---|
| | Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газар, Хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтсийн даргын албан тушаалд 3 жил ажилласан. 2022.03.17- 2019.04.01. /*Шүүхийн тамгын газар шинэчлэн байгуулагдсантай холбогдуулан тушаал гарсан.Үндсэн албан тушаал, түүний чиг үүрэг өөрчлөгдөөгүй* /<br>-Шүүхийн үйлчилгээг ил тод хүртээмжтэй байдлаар иргэдэд хүргэх, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг бэхжүүлэх, шүүн таслах ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх, дэмжлэг үзүүлэх, шүүхийн захиргааны ажилтнуудыг сургах, бэлтгэх, шүүгчдийг мэдээллээр хангах, иргэдийн мэдэх эрхийг хангах, шүүхийн процесс ажиллагаанд хяналт, судалгаа шинжилгээ хийх, санал дэвшүүлэх ажлыг удирдан зохион байгуулах чиг үүргийн хүрээнд нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг шүүхийн тамгын газрын даргын өмнө хариуцан тайлагнана.<br>1.Удирдах албан тушаалтны нэр: Д.Одхүү<br>-Холбоо барих мэдээлэл: Шүүхийн Тамгын газрын дарга байсан, шүүхийн Тамгын газрын дарга, odkhuu976@gmail.com, [redacted]<br>1.Өөрийн удирдлагад ажиллаж байсан: Ш.Бадамсүрэн<br>-Холбоо барих мэдээлэл: Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Тамгын газар шүүгчийн туслах, adamsuren.batpurev@gmail.com, [redacted]<br>2.Хамтран ажиллаж байсан: Д.Байгалмаа<br>-Холбоо барих мэдээлэл: Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Тамгын газар ерөнхий нягтлан, emma.baigal@gmail.com, [redacted]<br>3.Хамтран ажиллаж байсан: С.Үржинханд<br>-Холбоо барих мэдээлэл: Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Тамгын газар тооцооны нягтлан, Urjigtorjig@gmail.com, Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Ж.Самбуугийн гудамж, Шүүхийн байр<br>4.Холбоо барих мэдээлэл: У.Уянга, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн Тамгын газар, Хэргийн хөдөлгөөний хэлтсийн дарга, uyangaurgats@gmail.com, [redacted] |
| | Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газар, Хэргийн хөдөлгөөний удирдлагын 1-р хэлтсийн дарга **2019.04.01-2017.02.07** /Зарим шүүхийн Тамгын газрын бүтэц орон тоог шинэчлэн баталсан/<br>-Хэргийн хөдөлгөөний удирдлагыг хэрэгжүүлэх, мониторинг хийх, хэргийн хөдөлгөөний хяналт тавих, мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, тамгын газрын үйл ажиллагаанд хэргийн хөдөлгөөний удирдлагыг уялдуулан зохион байгуулах, хэргийн хугацаа хэтрэлтийн бууруулах, шүүх хуралдаан хойшлолтыг багасгах, хэргийн хөдөлгөөний системийн бүртгэлийг сайжруулж, хяналтыг хэрэгжүүлэх, эрхийн актын хугацааны хяналтыг хэрэгжүүлэх, шүүн таслах ажиллагааны өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа хангагдах, шүүхийн үйлчилгээ сайжирна. гүйцэтгэлийн үр дүнг шүүхийн Тамгын газрын даргын өмнө хариуцан тайлагнана.<br>1.Удирдах албан тушаалтны нэр: Д.Болор |

| | |
|---|---|
| | - Холбоо барих мэдээлэл: Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн Тамгын газрын дарга, dbolor4313@gmail.com, [redacted]<br><br>2.Хамтран ажиллаж байсан: Э.Ундрах<br>Холбоо барих мэдээлэл: Undrakh.umguulugch@gmail.com , [redacted]<br><br>3.Хамтран ажиллаж байсан: Д.Байгалмаа<br>-Холбоо барих мэдээлэл: Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Тамгын газар ерөнхий нягтлан, emma.baigal@gmail.com, [redacted]<br><br>4.Хамтран ажиллаж байсан: С.Үржинханд<br>-Холбоо барих мэдээлэл: Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Тамгын газар тооцооны нягтлан, Urjigtorjig@gmail.com, [redacted]<br><br>5.Өөрийн удирдлагад ажилладаг: Г.Рэвгээсүрэн<br>Холбоо барих мэдээлэл: Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Тамгын газар нягтлан, Revgeesuren.2017@gmail.com , [redacted] |
| | Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газар, Хэргийн хөдөлгөөний удирдлагын 1 дүгээр хэлтсийн даргын албан тушаалд 2 жил 2 сар ажилласан. 2017.02.07-<br>-Хэргийн хөдөлгөөний удирдлагыг хэрэгжүүлэх, мониторинг хийх, хэргийн хөдөлгөөний хяналт тавих, мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, тамгын газрын үйл ажиллагаанд хэргийн хөдөлгөөний удирдлагыг уялдуулан зохион байгуулах, хэргийн хугацаа хэтрэлтийн бууруулах, шүүх хуралдаан хойшлолтыг багасгах, хэргийн хөдөлгөөний системийн бүртгэлийг сайжруулж, хяналтыг хэрэгжүүлэх, эрхийн актын хугацааны хяналтыг хэрэгжүүлэх, шүүн таслах ажиллагааны өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа хангагдах, шүүхийн үйлчилгээ сайжирна. гүйцэтгэлийн үр дүнг шүүхийн Тамгын газрын даргын өмнө хариуцан тайлагнана.<br>1.Удирдах албан тушаалтны нэр: С.Амардэлгэр<br>Холбоо барих: Amardelger0309@gmail.com, [redacted]<br><br>2.Ажил хэргийн харилцаатай: Б.Энх-Эрдэнэ<br>Холбоо барих мэдээлэл: Шүүхийн ерөнхий зөвлөлийн эвлэрүүлэн зуучлалын хорооны удирдах зөвлөлийн гишүүн, Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгч, monadvoenkhee@yahoo.com ,Сүлд Эм Жи легал өмгөөллийн фирм, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, НҮБ гудамж 46 байр 1 тоот<br>3.Өөрийн удирдлагад ажиллаж байсан: Ш.Ундраа<br>Холбоо барих: Шүүхийн Сахилгын хороо, гишүүний туслах, anaardnu@gmail.com , [redacted]<br><br>4.Хамтран ажиллаж байсан: Б.Зулзаяа<br>-Холбоо барих мэдээлэл: Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүх, эвлэрүүлэн зуучлагч, |

| | |
|---|---|
| | Zulzaya1227@gmail.com , [redacted]<br>5.Өөрийн удирдлагад ажиллаж байсан: С.Бадамцэцэг<br>-Холбоо барих мэдээлэл: Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн Тамгын газар Хэргийн хөдөлгөөний хэлтсийн дарга, Badamtsetseg0305@gmail.com , [redacted]<br>5.Хамтран ажиллаж байсан: Т.Наранбат<br>Холбоо барих мэдээлэл: Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгч, Naranbat@gec.gov.mn, [redacted] |
| | Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын Захиргаа, хүний нөөцийн ахлах мэргэжилтний албан тушаалд 1 жил 7 сар ажилласан. 2017.02.07 -2015.07.01<br>-Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан гарсан тушаал. Шүүхийн Тамгын газрын хүний нөөцийг бүрдүүлэх, хувийн хэрэг, бүртгэл, судалгаа, мэдээллийн сан хөтлөх, шүүхийн захиргааны ажилтныг сургаж хөгжүүлэх, ажилтны нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг зохион байгуулах, шүүхийн Тамгын газрын дотоод ажлыг уялдуулан зохион байгуулах ажлыг хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн үр дүнг шүүхийн Тамгын газрын даргын өмнө хариуцан тайлагнана.<br>1.Удирдах албан тушаалтны нэр: Д.Болор<br>- Холбоо барих мэдээлэл: Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн Тамгын газрын дарга, dbolor4313@gmail.com, [redacted]<br>2.Хамтран ажиллаж байсан: Б.Цолмонгэрэл<br>Холбоо барих мэдээлэл: Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгч, tsolmongerel1231@gmail.com [redacted]<br>3.Хамтран ажиллаж байсан: М.Мөнх-Эрдэнэ,<br>Холбоо барих мэдээлэл: Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн Тамгын газар ерөнхий нягтлан, Muugii_court@yahoo.com , [redacted]<br>4.Өөрийн удирдлагад ажиллаж байсан: Э.Намжилцэрэн<br>Холбоо барих мэдээлэл: Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгч, namjaaerdene02@gmail.com, [redacted]<br>Холбоо барих мэдээлэл: Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгч, eerdenetuya563@gmail.com , [redacted] |
| | **Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1-р шүүхийн Тамгын газрын Захиргаа, хүний нөөцийн ахлах мэргэжилтний албан тушаалд 10 сар ажилласан. 2015.07.01.- 2014.09.11**<br>- Шүүхийн Тамгын газрын хүний нөөцийг бүрдүүлэх, хувийн хэрэг, бүртгэл, судалгаа, мэдээллийн сан хөтлөх, шүүхийн захиргааны ажилтныг сургаж хөгжүүлэх, ажилтны нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг хамгаалах арга |

| | |
|---|---|
| | хэмжээг зохион байгуулах, шүүхийн Тамгын газрын дотоод ажлыг уялдуулан зохион байгуулах ажлыг хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн үр дүнг шүүхийн Тамгын газрын даргын өмнө хариуцан тайлагнана.<br>1.Удирдах албан тушаалтны нэр: Д.Болор<br>- Холбоо барих мэдээлэл: Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн Тамгын газрын дарга, dbolor4313@gmail.com, [redacted]<br>2. Өөрийн удирдлагад ажиллаж байсан: Д.Чинзориг<br>Холбоо барих мэдээлэл: Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгч, chinzorig@ulaw.mn , [redacted]<br>3.Холбоо барих мэдээлэл: Хууль зүйн туслалцааны төвийн Улсын өмгөөлөгч, mtv.muugii@gmail.com, [redacted]<br>4.Өөрийн удирдлагад ажиллаж байсан: Л.Энхбаяр<br>-Холбоо барих мэдээлэл: Хувиараа хөдөлмөр эрхэлдэг, inkayra7754@gmail.com , [redacted]<br>5.Өөрийн удирдлагад ажиллаж байсан: С.Гантогтох<br>Холбоо барих мэдээлэл: ХААН банкны хуулийн хэлтэст хуульч, Gantogtokhsurenjav@gmail.com , [redacted] |
| | **Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн Тамгын газрын Шүүхийн зохион байгуулалт хариуцсан мэргэжилтний албан тушаалд 8 сар ажилласан. 2014.09.11.- 2014.01.15**<br>- Иргэн төвтэй шүүхийн үйлчилгээг иргэд, олон нийтэд тасралтгүй, нээлттэй, ил тод хүртээмжтэй байдлаар хүргэх, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг бэхжүүлэх, шүүх, шүүгчийн хараат бус, аюулгүй байдлыг хангах, шүүхийн хүний нөөцийн үйл ажиллагаа удирдах, шүүхийн нийтлэг үйлчилгээг зохион байгуулах чиг үүргүүдийн хүрээнд нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг шүүхийн Тамгын газрын даргын өмнө хариуцан тайлагнана.<br>1.Удирдах албан тушаалтны нэр: Н.Дагва<br>- Холбоо барих мэдээлэл: Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга асан, тэтгэвэрт /mail хаяг ашигладаггүй гэх/ [redacted]<br>1.Өөрийн удирдлагад ажиллаж байсан: Б.Нямжав<br>Холбоо барих мэдээлэл: Хөвсгөл аймгийн хяналтын прокурор, Nyamka_9009@gmail.com , [redacted]<br>Холбоо барих мэдээлэл: хувиараа хөдөлмөр эрхэлдэг, ganaa8425@gmail.com, [redacted]<br>3.Өөрийн удирдлагад ажиллаж байсан: Г.Оюунцэцэг<br>Холбоо барих мэдээлэл: Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгч, Oyunaag644@gmail.com, [redacted]<br>4.Хамтран ажиллаж байсан: Т.Ариунболд |

| | |
|---|---|
| | Холбоо барих мэдээлэл: Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгч, arnbold2460@gmail.com , [redacted]<br>5.Хамтран ажиллаж байсан: Б.Раушан<br>Холбоо барих мэдээлэл: Ховд аймгийн сум дундын анхан шатны шүүхийн шүүгч, Nurd_rau@yahoo.com , [redacted]<br>6.Өөрийн удирдлагад ажиллаж байсан: Э.Хандмаа<br>Холбоо барих мэдээлэл: Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн Тамгын газар тооцооны нягтлан, Haku_0615@yabhoo.com, Баянзүрх дүүрэг 2-р хороо Их засгийн өргөн чөлөө, шүүхийн байр |
| | **Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхэд шүүгчийн туслахын албан тушаалд 23 хоног, 2014.01.15-2013.12.23** / Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газраас шилжин ирэх санал тавьсан /<br>-Шүүхийн захиргааны тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-д заасан чиг үүрэг, холбогдох процесс хууль бусад хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх, тамгын газрын өдөр тутмын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, шүүн таслах ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх, эрх зүйч мэргэшлийн ур чадвар сайтай мэргэшсэн шүүгчийг бэлтгэх, шүүн таслах үйл ажиллагаанд шүүгчийн туслахын үүрэг оролцоог нэмэгдүүлж, шүүгчийн бие даасан хараат бусаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, гүйцэтгэлийн үр дүнг тамгын газрын даргын өмнө тайлагнана.<br>1.Удирдах албан тушаалтан: Д.Солонго.<br>Холбоо барих мэдээлэл: Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгч асан, sokosonya88@gmail.com [redacted],<br>2.Хамтран ажиллаж байсан: О.Солонго<br>-Холбоо барих мэдээлэл: Нийслэлийн Эрүү, Иргэний хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн Тамгын газрын дарга, solongo1615@gmail.com, [redacted]<br>3.Хамтран ажиллаж байсан: Ж.Амаржаргал<br>Холбоо барих мэдээлэл: Jargal1112@gmail.com, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Тамгын газар, Олон нийттэй харилцах мэргэжилтэн, [redacted]<br>4.Хамтран ажиллаж байсан: Г.Олонбаяр<br>Холбоо барих мэдээлэл: ЗГХ Агентлаг боловсролын ерөнхий газар, хууль эрх зүйн хэлтсийн газрын дарга, olonbayar.0712@gmail.com , [redacted]<br>5.Хамтран ажиллаж байсан: Д.Орхонтамир<br>Холбоо барих мэдээлэл: Архангай аймгийн сум дундын анхан шатны шүүхийн шүүгч, orkhomtamird@gmail.com, [redacted] |
| | **Нийслэлийн шүүхийн Тамгын хэлтэс, Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгчийн туслах бөгөөд шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалд 5 жил 6 сар ажилласан. 2008.06.02-2013.12.23. /Шүүхийн бүтэц зохион байгуулалт өөрчлөгдсөн/** |

| | |
|---|---|
| | - Шүүхийн захиргааны тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-д заасан чиг үүрэг, холбогдох процесс хууль бусад хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх, тамгын газрын өдөр тутмын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, шүүн таслах ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх, эрх зүйч мэргэшлийн ур чадвар сайтай мэргэшсэн шүүгчийг бэлтгэх, шүүн таслах үйл ажиллагаанд шүүгчийн туслахын үүрэг оролцоог нэмэгдүүлж, шүүгчийн бие даасан хараат бусаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, гүйцэтгэлийн үр дүнг тамгын газрын даргын өмнө тайлагнана.<br>1.Удирдах албан тушаалтан: Б.Батцэцэг<br>Холбоо барих мэдээлэл: b.batstesteg@yahoo.com, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн Тамгын газрын дарга, [redacted]<br>1.Хамтран ажиллаж байсан: Т.Батхүлэг<br>Холбоо барих мэдээлэл: turmunkhbatkhuleg@gmail.com , хүүхэд асрах чөлөөтэй, [redacted]<br>2.Хамтран ажиллаж байсан: Э.Нармандах<br>Холбоо барих мэдээлэл: narka0719@yahoo.com, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн Тамгын газар шүүгчийн туслах, [redacted]<br>3. Хамтран ажиллаж байсан: Б.Энхчимэг<br>Холбоо барих мэдээлэл: Өмгөөлөгч, enhchg16@gmail.com , өмгөөлөгч, [redacted]<br>Өөрийн удирдлага доор:<br>1.Хамтран ажиллаж байсан: Б.Батчимэг<br>Холбоо барих мэдээлэл: Batchimeg9008@gmaul.com, Нийслэл дэх иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Тамгын газар шүүгчийн туслах [redacted]<br>2.Хамтран ажиллаж байсан: Н.Гэрэлтуяа<br>Холбоо барих мэдээлэл: gereltuya@judcouncil.mn, Шүүхийн ерөний зөвлөл, Шүүхийн захиргаа удирдлагын газар эвлэрүүлэн зуучлал, иргэдийн төлөөлөгч хариуцсан рефрент, [redacted] |
| | **Нийслэлийн шүүхийн Тамгын хэлтэс, Баянзүрх дүүргийн шүүхийн шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалд 3 жил 4 сар ажилласан. 2008.06.02.- 2005.10.19**<br>-Процесс хууль бусад хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх, шүүхийн захиргааны ажилтны ёс зүйг чанд сахих, тамгын газрын өдөр тутмын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, шүүн таслах ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх, Шүүх хуралдааны бэлтгэлийг хангах, техник зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөх ажлыг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг тайлагнана.<br>1.Удирдах албан тушаалтан: Б.Зориг. |

|  |  |
|---|---|
|  | Холбоо барих мэдээлэл: Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгч, zrg_b@yahoo.com, [redacted]<br><br>2.Хамтран ажиллаж байсан: Э.Уянгасайхан,<br>Холбоо барих мэдээлэл: МӨХ-ны өмгөөлөгч, uyangasaikhan.e@gmail.com , [redacted]<br><br>3.Хамтран ажиллаж байсан: Л.Лхагвасүрэн,<br>Холбоо барих мэдээлэл: УИХ-ын Тамгын газарт ахлах зөвлөх, L.Lhyy@yahoo.com, [redacted]<br><br>Хамтран ажиллаж байсан: Т.Амартүвшин,<br>Холбоо барих: Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүх, Judgeamaraa@gmail.com, [redacted]<br><br>5.Хамтран ажиллаж байсан: Г.Даваахүү<br>Холбоо барих мэдээлэл: Хөвсгөл аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн шүүгч, davka1010@yahoo.com, [redacted] |
| **3.2** | **Эрх зүйчээс бусад мэргэжлээр эрхэлсэн ажил** |
|  | Баянзүрх дүүргийн шүүх, Баянзүрх дүүргийн шүүхийн зарлага /бичиг хүргэгч/-аар 9 сар ажилласан. **2005.10.19-2005.01.31**<br>-Шүүхээс төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, хуулийн этгээдэд хүргүүлэхээр явуулсан шүүхийн шийдвэр, баримт бичгийг түргэн шуурхай хүргэж холбогдох ажилтанд мэдэгдэх, бүртгэл судалгааг хийх, төрийн болон албаны нууцыг чандлан хадгалах, шүүн таслах болон шүүхийн Тамгын газрын үйл ажиллагааны хэвийн тасралтгүй байдлыг хангахад баримт бичиг хүргэж, техникийн үйлчилгээ үзүүлж, гүйцэтгэлийн үр дүнг шүүхийн Тамгын газрын даргын өмнө хариуцан тайлагнана.<br>1.Удирдах албан тушаалтан: Ё.Цогтзандан<br>Холбоо барих, Баянзүрх дүүргийн шүүхийн ерөнхий шүүгч, шүүгч асан, тэтгэвэрт, [redacted]<br><br>2.Удирдах албан тушаалтан: Ч.Отгонбаяр, Баянзүрх дүүргийн шүүхийн Тамгын албаны дарга асан, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгч, otgonbayar.chuluunbaatar@judges.mn [redacted]<br><br>3.Хамтран ажиллаж байсан: Э.Уянгасайхан<br>Холбоо барих мэдээлэл: МӨХ-ны өмгөөлөгч, uyangasaikhan.e@gmail.com , [redacted]<br><br>4.Хамтран ажиллаж байсан: Ц.Соёлмаа<br>Холбоо барих мэдээлэл: Хэргийн хөдөлгөөн хариуцсан референт, soyolmaa@judcouncil.mn, [redacted]<br><br>5.Хамтран ажиллаж байсан: Д.Мөнгөнтуул |

| | |
|---|---|
| | Холбоо барих мэдээлэл: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Munguntuul.dd@gmail.com, [redacted] |
| 3.3 | **Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар**<br>Монголын хуульчдын холбоо, Монголын өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн эсхүл хүний эрхийн чиглэлээр ажилладаг бусад холбоо, байгууллагын гишүүн бол хамгийн сүүлийнхээс эхлэн оны дараалаар нэрлэн бичиж, гишүүнчлэл тус бүрийг нотлох баримтыг хавсаргана |
| | Монголын хуульчдын холбооноос 2017.01.18-ны өдрийн №5511 дугаар хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн гэрчилгээ авсан өнөөдрийг хүртэл эзэмшиж байна. Монголын Хуульчийн холбоонд 2019 оны 08 дугаар сард “Хүүхэд асрах чөлөө” авсан шалтгаанаар түдгэлзүүлэх хүсэлт өгсөн бөгөөд 2022.03.20-ны өдөр хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сэргээлгэх хүсэлт гаргасан. Улмаар Монголын Хуульчийн холбооны ерөнхийлөгчийн 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 258 дугаар тушаалаар хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сэргээсэн.<br>/*холбогдох баримтыг хавсаргав/*<br>-2025.01 дүгээр сард Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хуралдаанаар хэлэлцээд “Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах салбар зөвлөлийн гишүүнээр бүртгэсэн. Улмаар 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/8 дугаар Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын захирамжаар “20225 онд ажиллах ажлын төлөвлөгөөг баталж байсан. */холбогдох баримтыг хавсаргав./* |

## ДӨРӨВ. ХУУЛЬ ЗҮЙН ӨНДӨР МЭРГЭШИЛ

| | |
|---|---|
| 4.1 | Хууль зүйн өндөр мэргэшилтэй.<br>Хүсэлт гаргагчийг хууль зүйн өндөр мэргэшилтэй /хууль зүйн өндөр мэдлэг, чадвар, туршлагатай, мэргэжлийн өндөр ёс зүйтэй/ гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 мэргэжлийн үйл ажиллагааг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалаар бичиж, тодорхойлох бөгөөд үйл ажиллагаа тус бүрийг явуулсныг нотлох баримтыг хавсаргана. Ийм үйл ажиллагаа тус бүрийн талаар дараах мэдээллийг заавал бичнэ.<br>-үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа;<br>-үйл ажиллагааны гол агуулга;<br>-үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ;<br>-үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр /нэрс аль болох давхцахгүй байх/, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/;<br>-тухайн үйл ажиллагааны хүрээнд хамтран ажиллаж байсан, өөрийн удирдлагад ажиллаж байсан, ажил хэргийн харилцаатай байсан гурваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл /утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажлын газрын хаяг зэрэг/;<br>-хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар. |

4.1 Хүсэлт гаргагч миний бие УДШ-ийн 8 дугаар тогтоол, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5 дахь заалт болон Төрийн албаны тухай хуульд заасан албан хаагчид тавигдах эрх зүйч мэргэжилтэй байх боловсрол, мэдлэг, туршлага, мэргэшсэн байдлын болзол, шаардлагыг хангаж, хуульчаар ажилласан шаардлагад нийцэх албан тушаалд шүүхийн байгууллагад эрх зүйч, хуульчаар 19 жил 7 сар ажилласан байна. Үйл ажиллагааны талаар:

**Нэгдүгээрт:**

**Үйл ажиллагааны нэр:** "Шүүхийн цахим туслах" (AI) системийн хөгжүүлэлт ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд инновац нэвтрүүлэх

**Эрхэлсэн газар, хугацаа:** Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Тамгын газар, Шүүхийн ерөнхий зөвлөл

Хугацаа: 2026 оны 1 дүгээр сараас эхлүүлсэн.

**Үйл ажиллагааны гол агуулга:** Өнөөдрийг хүртэл 10 гаран жилийн хугацаанд хөгжүүлэлт хийгээгүй технологийн хоцрогдлоос шалтгаалан анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгч, шүүхийн захиргааны ажилтанд зохиомол ажлын ачаалал үүсээд байгаа. "Цахим шүүх 2.0" төсөл нь хэдийгээр хэрэгжиж байгаа боловч, өргөн хүрээнд, үе шаттай хэрэгжиж буй тул богино хугацаанд одоогийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж чадаагүй байх тул тус шүүхийн шүүгч, шүүхийн захиргааны албан хаагчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, алдаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хэрэг хянан шийдвэрлэх хугацааг багасгах, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, шүүхийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор хиймэл оюун ухаан бүхий (AI)-ийг шүүхийн үйлчилгээнд "Шүүхийн цахим туслах" хэлбэрээр дотооддоо ашиглах, цаашлаад нийт шүүхийн хэмжээд хөгжүүлж болох инновацыг нэвтрүүлэх,

**Үр дүн:** "Шүүхийн цахим туслах" систем нь захиргааны хэрэг маргааныг хяналтын шатны шүүхийн тогтоол /2019-2025 он/, давж заалдах шатны шүүхийн магадлал /2015-2025 он/, анхан шатны шүүхийн шийдвэр болон захиргааны хэрэг маргаан шийдвэрлэхэд хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөж буй хууль, дүрэм, журам, холбогдох тусгай зөвшөөрөл бүхий байгууллагаас гардаг стандарт, шүүхийн шийдвэр, магадлал, процессын хураангуй бүхий хаалттай, аюулгүй байдлыг хангасан мэдээллийн сан үүсгэсэн. Уг өгөгдлөөс мэдээллийг боловсруулан нууцлал хийх, хайлтын хязгааргүй мэдээллийг 85-аас дээш хувиар илрүүлэх, судалгаа, дүн шинжилгээ хийх, шийдвэрийн хураангуй төсөл боловсруулах, өгсөн баримтад дүн шинжилгээ хийж шүүгч, шүүгчийн туслахад "цахим туслах"-ын үүргээр дэмжлэг үзүүлнэ. Цаашлаад иргэдэд чиглэсэн ижил төстэй маргааныг харах, урьдчилан таамаг дэвшүүлэх боломжтой VR үйлчилгээний түвшинд хүртэл хөгжүүлэх боломжийг туршиж үзсэн нь амжилттай болсон.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 01/502 дугаартай албан бичгээр шүүхийн цахимжилтын бодлого "Цахим шүүх 2.0" системтэй нийцэх эсэх, мэдээллийн аюулгүй байдлын шаардлага хангах эсэх, бусад шүүхэд нэвтрүүлж болох эсэхийг Шүүхийн цахим иновац цахимжуулалтын хороо, Цахим хөгжил, мэдээлэл технологийн удирдлагын газар, Шүүхийн цахимжилтын төв төслийн гүйцэтгэгч байгууллагаар судлуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ" гэж чиглэл ирүүлсэн тул шүүхийн Тамгын газрын 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 82 дугаар албан бичгээр танилцуулга, мэдээллийг хүргүүлсэн бөгөөд албан ёсны шийдвэр гарах хүртэл "Цахим туслах" системийн "data"-г баяжуулах, хиймэл оюун ухааныг сургах, дотооддоо ашиглаж буй

тогтоолын сангийн системтэй интеграцид оруулах гэх мэт систем хөгжүүлэлтийг тасралтгүй туршин нэвтрүүлж байна. /хавсралтаар албан бичиг, танилцуулга хавсаргав.

**Жишээ:** Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэж буй хэрэг маргааны 87 хувь нь эцэслэн шийдвэрлэгдэж, Хяналтын шатны шүүхээр хянагдсан нийт маргааны 2024 онд 46.7%, 2025 онд 51.6 % өмнөх оноос 4.9% өссөн байна. Мөн шүүхийн захиргааны ажилтнуудын зүгээс ижил төстэй маргааны шийдвэрлэлтийг хайх, оновчтой үр дүнг олох, дүн шинжилгээ хийх, shuukh.mn системд шийдвэр, магадлал байршуулахад нууцлалыг гар аргаар хийх гэх мэт шалтгаанаар ажлын бүтээмж бууруулах, ачааллыг зохиомлоор нэмэгдүүлэх, алдаа зөрчил гарах эрсдэл бий болох мөн шүүгч, шүүгчийн туслах shuukh.mn системээс ижил төстэй маргааныг хайхад илэрц оновчгүй, хэт олон илэрц харуулснаар хайсан үр дүнг олохын тулд шийдвэр, магадлалыг нэг бүрчлэн орж, унших ингэснээр ажлын цагийн хуваарилалтыг алдагдуулах, илүү цагаар ажиллах, ачааллыг нэмэгдүүлэхэд тодорхой хэмжээгээр нөлөөлж байна. Системийг сайжруулснаар ажлын зохиомол ачааллыг бууруулах, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, шүүхийн үйлчилгээ сайжрах, иргэдийн мэдэх эрхийг хангах, цаг хугацаа хэмнэх, судалгаа-шинжилгээний эргэлтэд оруулснаар хөндлөнгийн хяналтыг сайжруулснаар шүүхэд итгэх иргэдийн итгэл нэмэгдүүлэх саналыг 2024.11.20-ны өдрийн 249 дүгээр албан бичгээр ШЕЗ-ын шүүхийн цахимжилт хариуцсан ажлын хэсэгт хүргүүлсэн. */ШЕЗ-н 2026.04.01№01/502, ШТГ-ын 2026.03.25 №82, 2024611620 1249 тev тev хүргүүлсэн танилцуулга хавсаргав /*

Удирдах албан тушаалтан:

**Хамтран ажилласан:** Г.Даваадорж

Холбоо барих мэдээлэл: Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, Шүүхийн цахимжилт хариуцсан хорооны гишүүн, davaadorj@judcouncil.mn, [redacted]

**Үйл ажиллагааны хүрээнд хамтран ажилласан:**

Холбоо барих мэдээлэл: О.Сэлэнгэ, сургагч багш, selenge137@gmail.com , [redacted]

**Өөрийн удирдлагад ажилласан:**

Холбоо барих мэдээлэл: Х.Гантулга, Хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтсийн дарга, gantulga.court@gmail.com, [redacted] Akmaralmaku@gmail.com [redacted]

**Хоёрдугаарт:**

**Үйл ажиллагааны нэр:** Шүүхийн үйлчилгээний хүртээмж ба мэтгэлцэх эрхийн баталгааг хангах.

**Үйл ажиллагаа эрхэлсэн газар, хугацаа:** Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх, 2025 он

**Үйл ажиллагааны гол агуулга:** Цахим хуралдаанд оролцох, өмгөөлөгчийн ганцаарчилсан уулзалт хийх, тухайн өдрийн шүүх хуралдааны товыг багцлан гаргадаг онцлогоос шалтгаалан дараагийн хурлыг хүлээх, бусад шүүхийн шүүх хуралдаанд цахимаар оролцох боломжийг бүрдүүлж, шүүхийн үйлчилгээний орчин

нөхцөлийг сайжруулсан. Шүүхийн хуралдааны жишиг “цахим шүүх хуралдааны танхим”-ыг ашиглалтад оруулснаар гэрээсээ, малын бэлчээр дээрээс, хотын түгжрэл дунд шүүх хуралдаанд оролцох, шүүхийн заал танхимын хүрэлцээгүй асуудлыг шийдвэрлэх, шүүхийн цахимжилтыг эрчимжүүлсэн үйл ажиллагааг явуулсан.

**Үр дүн:** -Хэргийн оролцогч, өмгөөлөгчийг нийслэл хотын түгжрээ, цаг хугацаа, санхүүгийн хувьд хэмнэлттэйгээр бусад шүүхэд зарлагдсан шүүх хуралдаанд зайнаас цахимаар оролцох боломжийг бүрдүүлсэн.

- Өмгөөлөгчөөс шалтгаалан шүүх хуралдаан давхацсан шалтгаанаар шүүх хуралдааныг хойшлуулах асуудлыг бууруулахад эерэг нөлөө үзүүлсэн.
- Шүүхийн захиргааны байгууллага нь хэдий дэвшилтэд стандартын тоног, төхөөрөмжөөр бүрэн хангагдаагүй ч гэсэн дотоод нөөц бололцоогоо ашиглан, төхөөрөмжид сайжруулалт тус шүүхийн шүүх хуралдааныг 2025 оны 2 дугаар сарын 4-ний өдрөөс эхлэн хуульд хаалттай гэж заасан бусад нээлттэй шүүх хуралдааныг шууд дамжуулж, шүүх хуралдааны нээлттэй ил тод байдлыг хангасан.

**Жишээ:** 1.Шүүхийн шүүн таслах ажиллагааг хэвийн тасралтгүй явуулах нөхцөл бололцоог хангах, шүүх хуралдаанд оролцогч талууд шаардлагатай баримт материалаа хэвлэн авах, хүсэлтээ цахимаар илгээх, өөр шүүхийн шүүх хуралдаанд зайнаас цахимаар /онлайн/ оролцох техникийн нөхцөлийг бүрдүүлсэн. Улмаар интернэтэд холбогдсон техник, тоног төхөөрөмжөөр тохижуулах ажлыг Монголын өмгөөлөгчдийн холбоотой хамтран зохион байгуулснаар өнөөдрийн байдлаар өмгөөлөгчид бүрэн ашиглаж, хүний эрхийг хангаж ажиллаж байна.

Үзэх линк: https://admincourt2.gov.mn/site/single/4646
https://www.facebook.com/reel/3911096162521638 Талархал:

Холбоо барих мэдээлэл: monadvoenkhee@yahoo.com ,Сүлд Эм Жи легал өмгөөллийн фирм, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, НҮБ гудамж 46 байр 1 тоот

2. Шүүх хуралдааны шууд дамжуулалтыг шүүн таслах ажиллагаанд бүрэн нэвтрүүлсэн. “Нээлттэй шүүх хуралдааны бичлэгийг шүүхийн цахим хуудаст байршуулах журам” 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжихээр батлагдсан. Холбогдох хууль, журамд заасан болон эрчим хүний хязгаарлалтаас бусад бүх **шүүх хуралдааныг цахим платформуудаар (YouTube, Facebook) шууд дамжуулан**, иргэдийг үнэн зөв, бодит мэдээллийг албан ёсны эх сурвалжаас шууд хүргэх, олон нийтийн хяналтыг бий болгож, шүүхийн хараат бус, бие даасан байдлыг хангах ажлыг бодитой болгосон. 2025 онд 722 шүүх хуралдааныг шууд дамжуулснаас 1 сарын хугацаанд 74 шүүх хуралдааныг шууд дамжуулахад 22128 иргэн үзсэн байна. 2026 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар 340 шүүх хуралдааныг шууд дамжуулсан. Шууд дамжуулалтын талаарх тоон судалгаа, мэдээллийг тогтмол ил тод байршуулан олон нийтийг мэдээллээр хангаж, оролцоог нэмэгдүүлж байна. */2026.03.02 №47 албан бичиг хавсаргав/*

Линк үзэх: https://www.facebook.com/reel/1401686654831646
https://www.facebook.com/reel/2041600319655898

**Удирдлагын хүрээнд хамтран ажилласан:**

Холбоо барих мэдээлэл: Д.Баатархүү, baatarkhuu.dorjgochoo@judges.mn , [redacted] Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч /ерөнхий шүүгч асан/, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо Их тойруу 81/1 Захиргааны хэргийн шүүхийн нэгдсэн байр,

**Үйл ажиллагааны хүрээнд хамтран ажилласан:** Л.Данзанноров,

| | |
|---|---|
| | Холбоо барих: Монголын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч, [redacted] info@umguulul.mn [redacted]<br>2.Ажил хэргийн харилцаатай: Б.Энх-Эрдэнэ<br>**Өөрийн удирдлагад ажилласан.**<br>Холбоо барих мэдээлэл: О.Болорчулуу, Мэдээллийн технологийн мэргэжилтэн, gantulga.court@gmail.com, [redacted]<br>**Гуравдугаарт:**<br>**Үйл ажиллагааны нэр:** Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, хүний эрхийг хангах, шүүн таслах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх<br>**Эрхэлсэн газар, хугацаа:** Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх, 2025 он<br>**Үйл ажиллагааны агуулга:** Хэдийгээр ШЕЗ-өөс албан ёсны бүртгэлтэйгээр эхлүүлсэн систем биш боловч шүүх дотооддоо ашиглах зорилгоор санаачлан нэвтрүүлсэн. Шүүн таслах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор "Шүүхийн тогтоолын сан"-н кодыг шинэчлэн Үндэсний дата төвд байршуулж, ашиглалтад оруулж, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээр хянагдсан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гаргасан гомдлыг хэвээр, өөрчлөлт, хүчингүй болгосон эрхийн актыг байршуулах. Уг системд нэвтрэх эрхийг захиргааны хэргийн анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхэд нээж өгөх улмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, хүний эрхийг хангагдана.<br>**Үр дүн: 1. “Тогтоолын цахим сан”**-д 2016 оноос хойш анхан шатны шүүхийн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гаргасан гомдлыг хянан шийдвэрлэсэн нийт 6979 шүүхийн тогтоолыг байршуулж, уг системд нэвтрэх эрхийг захиргааны хэргийн анхан шатны шүүх, давж заалдах шатны шүүхийн шүүгчид, хяналтын шатны шүүхийн шүүгч, шүүхийн академид тус тус нээж, судалгаа шинжилгээ хийх боломжийг бүрдүүлсэн.<br>2. Системүүдийн хоорондын уялдаагүй байдал, лицензгүй программ ашиглалтаас үүдэлтэй **кибер аюулгүй байдлын эрсдэл** болон ажлын ачаалал нэмэгдүүлж буй давхардсан үйлдлүүдийг автоматжуулах, **техник шийдлийн сайжруулалтын** саналыг 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 251 дүгээр албан бичгээр ШЕЗ-д хүргүүлсэн. /*холбогдох баримтыг хавсаргав*/<br>**Жишээ:** Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэгдэж буй маргааны 80 гаран хувь нь хүчин төгөлдөр болж байна. Түүнчлэн МУ-ын хэмжээнд шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гарч буй гомдлыг хянан хэлэлцдэг онцлогтой шүүхийн хувьд энэхүү оюун дүгнэлт бүхий **тогтоолын сан**г судалгаа шинжилгээний эргэлтэд оруулах нөхцөлийг бүрдүүлж тогтмол дата баяжилтыг хийж байна. Энэхүү тогтоолын санг судалгаа, шинжилгээ хийх хүсэлт гаргасан судлаач, оюутан, хуульч, өмгөөлөгчдөд “Шүүхийн тогтоолын сан”-ын нэвтрэх эрхийг нууцын баталгаа гаргуулж, тодорхой хугацаа заан ашиглуулж байна.<br>УДШ, Шүүхийн академи, Нийслэл дэх болон орон нутгийн анхан шатны 22 шүүх тус бүрд эрх нээж өгснөөр шүүн таслах ажиллагаанд хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, уулзалт хэлэлцүүлгийг хийх явдал нэмэгдэж байна.<br>Тогтоолын сан: https://togtool.court.gov.mn / эрх: 21unurjargal/<br>Үзэх линк: https://www.facebook.com/reel/1913469035923549 /<br>**Үйл ажиллагааны хүрээнд хамтран ажилласан:** |

| | |
|---|---|
| | Э.Амарсанаа, amarsanaa_ts@judcouncil.mn, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Тамгын газрын дарга, [redacted]<br>**Өөрийн удирдлага доор ажилласан:**<br>Холбоо барих мэдээлэл: Х.Гантулга, Хэргийн хөдөлгөөний хэлтсийн дарга, gantulga.court@gmail.com, [redacted]<br>Холбоо барих мэдээлэл. С.Уганзаяа, Нийслэл дэх Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, uugnaa.zaya@gmail.com, [redacted]<br>**Дөрөвдүгээрт:**<br>**Үйл ажиллагааны нэр:** Хуулийн хэрэгжилтийг хангах, журмын зохицуулалтыг хуульд нийцүүлэх<br>**Эрхэлсэн газар, хугацаа:**Шүүхийн ерөнхий зөвлөл, 2024 он<br>**Үйл ажиллагааны агуулга:** “Захиргааны хэргийн шүүхэд харьяалагдах маргааны онцлогийг харгалзан уг журмын холбогдох заалтад өөрчлөлт оруулж, төрийн байгууллага болон нийтийн албан тушаалын нэрийг нууцлах шаардлагагүй болох талаар хуулийн холбогдох заалтыг зөрчсөн байх тул хууль нийцүүлж, журамд өөрчлөлт оруулах, төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй ил тод байдлыг хангах, иргэдийн хяналт тавих эрхийн баталгааг хангах чиглэлээр судалгаа хийж ШЕЗ санал хүргүүлсэн.<br>**Үр дүн:** Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 94 дүгээр тогтоолоор “Шүүхийн шийдвэрийн цахим хуудаст байршуулах журам”-д “Захиргааны хэргийн оролцогч нь захиргааны байгууллага бол түүний нэр, үйл ажиллагаа явуулж байгаа хаягийг шүүхийн шийдвэрт нууцлахгүй” гэж нэмэлт, өөрчлөлт оруулж баталсан.<br>Үзэх линк: https://judcouncil.mn/site/decision_full/204<br>**Жишээ:** Шүүхийн ерөнхий зөвлөлд “Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналыг 2024 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 30 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Улмаар ШЕЗ-өөс журамд өөрчлөлт оруулах саналыг авах хүсэлт ирүүлсний дагуу 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 56 дугаар албан бичгээр дэмжсэн болон нэмж гаргасан саналыг Шүүхийн ерөнхий зөвлөлд албан тоотоор хүргүүлж, өөрчлөлт оруулах саналыг дахин хүргүүлсэн.<br>Шүүхийн ил тод байдал, шударга ёс, иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, эрх зүйн мэдлэг, мэдээлэлд тэгш хүртээмжтэй орчныг бүрдүүлэх нь шүүх эрх мэдлийн шинэ шатны хөгжилд чухал хувь нэмэр оруулах ач холбогдолтой гэж үзээд Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогын баримт бичиг, Шүүхэд мэдээллийн технологи, шүүхийн үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх нэгдсэн бодлогын хүрээнд “Шүүхийн цахимжилтын зөөлөн дэд бүтцийг боловсруулж, нэвтрүүлэх ажил эхэлсэнтэй холбогдуулан “Шүүхийн шийдвэрийн цахим сангийн хэрэглээ, өнөөгийн нөхцөл байдалд хийсэн судалгааны тайлан”-г ажлын хэрэгцээнд ашиглуулахаар 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 273 дугаар албан бичгээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Р.Ононгчимэг, цахимжилт хариуцсан ажлын хэсэгт хүргүүлсэн.<br>**Удирдах албан тушаалтны нэр**: /2022.12-2023.12 он/ |

| | |
|---|---|
